

1

Living the LOTUS

2015

Тусгай
дугаар



Buddhism in Everyday Life

2015 оны айлдвар

Алхам бүрээ нягталж, урагш тэмүүлцгээе

Рисшо Косей кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо

*«Мөргөлийн гурван эрдэнийг эрхэмлэх» ба
«Бодисадвагийн үйлийг хэрэгжүүлэх»*



Он солигдож шинэ он гарлаа. Гишүүд та бүгдэд дор бүрнээ шинэ ондоо хийж бүтээхээр бодож тунгаасан зүйл бий буй за. Өнгөрсөн жил Их ариун ордон баригдсаны 50 жилийн ой гэсэн тэмдэглэлт жил тохиож, олон зуун гишүүд ойн баярын мөргөлөөр ирцгээсэн. Их ариун ордны барилга нь буддын шашны шинж чанар, Үүсгэн байгуулагчийн хүсэл залбиралыг өөртөө шингээсэн байдаг. Сүсэгтэн олон залбирахаар ирэхдээ тэрхүү үүсгэн байгуулагчийн хүсэл эрмэлзлийг эргэн санаж, урьдынхаасаа ч илүү бурхны зам мөрт шамдах болсон хүн олон байгааг хараад миний сэтгэл маш их эрч хүчийг мэдэрсэн.

Би өнгөрсөн жилийг “Их ариун ордон баригдсаны 51 дэхь жилийг угтах түүхэн тэмдэглэлт жил” хэмээн зарласан. Энэ нь Ариун ордны 50 жилийн ойгоор дамжуулан бүгдээрээ хамтдаа нэг алхам урагшилцгаая, сэтгэлээ засаж бурхны зам мөрөөр алхацгаая гэсэн уриа байсан билээ. Манай байгууллагын гол шүтээн босоо дүртэй байдаг нь ийм өөдрөг тэмүүлэл, эрч хүчтэй байхын билэгдэл бөгөөд Үүсгэн байгуулагчийн хүсэл ч адилхан байсан гэж хэлж болно. Энэ жил ч гэсэн үргэлж урагш тэмүүлж, амжилт бүтээл гаргахын төлөө хичээнгүйлэн шамдвал зохилтой.

Тэгэхээр “2015 оны зорилт”-ыг дараах байдлаар тодорхойллоо. Өнгөрсөн жил Их ариун ордон баригдсаны 51 жилийг угтах жил хэмээн үйл ажиллагаагаа явуулж ирсэн.

Энэ жилээс Мөргөлийн гурван эрдэнэд тулгуурлан “Зорилт тавьж” сургаал номоо дэлгэрүүлцгээе. Амьдрал гэдэг нарийн ээдрээтэй зүйл болохоор хэцүү асуудалд унахад амархан байдаг. Бодит амьдрал ийм байдаг ч гэсэн, чухал нандин зүйл юу болохыг үргэлж санаж явахын төлөө арга ухаанаа зарах хэрэгтэй.

Мөн Шагжамүни бурхан багш болон Үүсгэн байгуулагч, Их дагагч Мёокоо нарынх шиг энэрэн нигүүлсэх сэтгэл, хүний уг мөн чанар болох гэгээлэг, эелдэг, халуун дулаан сэтгэлийг эрхэмлэн, бодисадвагийн үйл (хүний уг зам мөр)-г үргэлжлүүлэн хэрэгжүүлцгээе.

Нэмэлт

Японы зүүн бүсийн нутагт болсон байгалийн гамшиг болон гамшигийн улмаас өөд болсон талийгаачдын сүнсийг аргадах, бурхны хутаг олох замыг нь тэгшитгэх мөргөл, залбирлыг энэ жил ч гэсэн марталгүй үргэлжлүүлэн үйлдэцгээе.

Эртний мэргэн үгэнд «Нэг жилийн төлөвлөгөө бол амуу будаа тарих нь зөв. Арван жилийн төлөвлөгөө бол мод таривал зохилтой. Нэг насны төлөвлөгөө бол хүн өсгөн хүмүүжүүлэхтэй энэ зэрэгцэх зүйл үгүй» хэмээх үг байдаг. Дэлхийн хойшдын ирээдүйг бодоод үзвэл хоол хүнсний аюулгүй байдлыг хангах, цөмийн зэвсэг, байгаль орчны асуудал гээд бидний анхаарлыг татах асуудал олон байгаа гэж бодож байна. Тийм болохоор хувь хүн, салбар, нийгэмлэг, байгууллагын хүрээнд гэх мэтээр

бололцооныхоо хэрээр амуу будаа тарьж, мод суулгах, хүнийг боловсруулж хөгжүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулж, бүс нутаг, улс орон, дэлхий нийтийн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулцгаая.

Энэ хүртэлх гол агуулга өнгөрсөн жилээс өөрчлөгдөөгүй. Харин үргэлж шинэлэг сэтгэлээр үйл ажиллагаагаа явуулах гэдэг үүднээс бага зэрэг зүйл нэмж орууллаа.

Энэ жилийн гол зорилт бол «Мөргөлийн гурван эрдэнэд тулгуурлах» ба «Бодисадвагийн үйлийг хэрэгжүүлэх» болно.

Манай байгууллага 70 жилийн ой буюу 2008 оноос айл бүрт Гол шүтээн залах үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн. Ийнхүү түүхийн явцад Мөргөлийн гурван эрдэнийг эрхэмлэн шүтэх гэсэн буддын шашны үндсэн хэлбэр төрх манай байгууллагад бүрэлдэн тогтсон билээ.

Гол шүтээн болох «Бурхан», Шагжамүни бурхан багшийн сургаал болох «Ном», номын анд нөхөд буюу санга болох «Хуврага» гэсэн 3 эрдэнийг эрхэмлэн шүтэх үндсэн хэв маяг бүрэлдэн тогтох үйл явдлаар дамжуулан гишүүн бүр Бурхан багшийн шавь гэдгээ илүү ухамсарлан, бурхны зам мөрд зүтгэх- энэ нь манай нийгэмлэгийн үндсэн үйл юм.

Түүнчлэн гэр бүл, нийгэм, төр улс, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулах гэсэн Бурхан багшийн хүслийг хэрэгжүүлэхийн төлөө бодисадвагийн зам мөрөөр алхах нь гишүүд бидний үүрэг билээ. Үүнийг хэрэгжүүлэх хөдөлгөгч хүч нь Шагжамүни бурхан багш болон Үүсгэн байгуулагч, Их дагагч Мёокоо багш нарынх шиг энэрэн нигүүлсэх сэтгэл, хүний уг мөн чанар болох гэгээлэг, эелдэг, халуун дулаан сэтгэл юм.

Юу хийхээ тодорхой болгож, түүнийгээ хэрэгжүүлэхийг тулд төвлөрөх

Үүнийг гишүүд та бүхэн аль хэдийн мэдэж байгаа байх. Гэвч бодит амьдрал нүд ирмэхийн зуур урсан өнгөрдөг. Юу чухал болохыг ойлгож байгаа ч өмнөх зүйлтэйгээ зууралдаж байх зуур өдөр өнгөрчихсөн байх нь олонтой.

Тийм болохоор би энэ жил “«Зорилт» тавьж сургаалаа түгээцгээе” гэж уриалсан билээ.

Зорилт гэдэг үг нь сэдэв, хүсэл, тэмүүлэл зэрэг олон янзын утгаар хэрэглэгддэг. Нэг үгээр хэлбэл хийх ёстой зүйл, явах гэж байгаа зүг чигээ тодорхой болгох гэсэн үг. Жишээлбэл “Тэр хүн аз жаргалтай болоосой” хэмээн хүсэж, чин сэтгэлээсээ харилцах нь зорилготой амьдрахын нэг жишээ болно.

Нийгэмлэг бүрт харьяа дүүргийнхээ онцлог, бодит байдлыг тусгасан өөрийн гэсэн зорилт, уриа байдаг. Гишүүдэд ч гэсэн сүсэг бишрэлд тулгуурласан өөрийн гэсэн зорилт байдаг. Үүнээс гадна иргэний хувьд, нөхөр, эхнэр, эсвэл хүүхдийн хувиар ч гэсэн ямар нэг зорилго тавьсан байж болно.

Тэр дундаас буддын шашинтан хүний хамгийн чухал зорилт бол “Бурхан багшийг үлгэрлэн дууриаж, энэрэнгүй сэтгэлтэй хүн болох” юм. Үүнийг ухамсарлах юм бол цаашдаа хэрхэн бурхны үйл хийвэл зохих, яг одоо юу хийх ёстой болох нь аяндаа тодорхой болж ирнэ. Зорилт тавих нь үр бүтээлтэй, бодит төлөвлөгөөтэй



Түүнчлэн энэ жилийн зорилгод “Амьдрал гэдэг нарийн ээдрээтэй зүйл болохоор хэцүү асуудалд унахад амархан байдаг. Бодит амьдрал ийм байдаг ч гэсэн, чухал нандин зүйл юу болохыг үргэлж санаж явахын төлөө арга ухаанаа зарах хэрэгтэй.” гэж хэлсэн. Арга ухаан гэдэг нь сайн арга хайж олохыг заах нь нийтлэг боловч утгаа бол “бурхны зам мөрт сэтгэл зүрхээ зориулах” гэсэн буддын шашны утгатай үг юм.

Бидний өдөр тутмын амьдралд хийх ёстой зүйл олон байдаг. Хобби, сонирхол, зугаа цэнгэл гээд сэтгэл татагдах зүйл ч олон. Хоёр туулай хөөсөн хүн хоосон хоцордогийн үлгэрээр юм юм руу үсчсэний эцэст бүгдээрээ хагас дутуу юм болж хоцрох үе ч цөөнгүй тохиолддог.

Яам тамгын газар гэдэг үгэнд ордог ханз үсэг нь “хэмнэх ба эргэн харах” гэсэн 2 утгатай гэдэг. Улс төр шиг том бүтэц зохион байгуулалт бий болохын хирээр хэмнэж хасах болон эргэн харах гэсэн зүйлийг санаж явахгүй бол ээдрээ төвөгтэй зүйлтэй заавал тулгардаг учраас ийм ханз орсон байдаг байна.

Амьдралд огт хэрэггүй зүйл гэж байхгүй байж магадгүй ч, яг одоо хийх ёстой зүйл юу болохыг эргэцүүлж, түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд зарим нэг зүйлийг орхих шийд гаргах нь заримдаа хэрэгтэй.

Мөн бид нар өдөр бүрийн завгүй амьдралдаа автан чухал зүйлдээ анхаарал хандуулж чадалгүй, нэг л мэдэхэд мартчихсан байдаг.

Миний хувьд байнга мартчих гээд байдаг болохоор ширээн дээр нүдэнд харагдах газар хэд хэдэн чухал зүйлээ бичээд тавьчихдаг. Эсвэл тэмдэглэл хийж хавтаслах юмуу шаардлагатай үед хүрэмнийхээ хармаанд хийчихдэг. Сайхан үнэр бие сэтгэлд уусан шингэдэг шиг тэр үгээ уншиж, дахин дахин хэлээд байхаар аяндаа сэтгэлд шингэн уусдаг билээ.

Тэгэхээр цагийг хэрхэн ашиглаж байгаагаа, аливаа зүйлийг хийх арга барил зэрэг хэрхэн амьдарч байгаагаа яг одоо дахин нэг удаа эргэцүүлэн бодож, тухайн нөхцөл байдалд таарсан арга ухааныг олж хэрэгжүүлбэл зохилтой.

Энэрэн нигүүлсэх сэтгэл, хүний уг мөн чанар болох эгээлэг, эелдэг, халуун дулаан сэтгэлийг эрхэмлэн бага багаар урагшлая

Энэ жил дэлхийн 2-р дайнаас хойш 70 жилийн нүүр үзэж байна. Японы хүн амын дөрөвний гурваас илүү хувийг дайны дараа төрсөн хүмүүс

эээлж байгаа буюу 100 саяд хүрээд байна. Эсрэгээр дайн үзсэн хүмүүс хөгширч, жил ирэх тутам дайны талаар асууж лавлах хүн ховордсоор



байна. Тиймээс одоо ахмад буурлуудаас дайны туршлага, мөн энх тайвны хүсэл мөрөөдлийнх нь талаар асууж суралцах хэрэгтэй. Энэ нь ирээдүйг бүтээн байгуулахад нэн чухал зүйл билээ.

Хүн төрөлхтөн түүхийн ямар ч цаг үед дайн тэмцлийн гашуун түүхийг давтсаар ирсэн. Одоо ч гэсэн дэлхийн өнцөг булан бүрт дайны гал дүрэлзэн ассаар байна. Япон улс үндсэн хуулийн хүрээнд 70 жилийн турш энх тайвныг баримталж ирсэн боловч энэ нь мөнхөд үргэлжилнэ гэсэн баталгаа байхгүй.

Эртний Хятадын судар бичигт “Нийгэм хэдий энх амар байсан ч, нийгмийн ороо бусгааг үргэлж санаж яв” гэдэг үг байдаг. Энэ нь дайнд бэлэн бай гэсэн үг биш, ямар ч үед энх тайвны үйлийг хойш тавин залхуурч болохгүй гэсэн утгатай.

Мөн Күнзийн их ухаанд “Өрх гэр, төр засаг, дэлхийн энх тайван нь өөрийн биеэ хөгжүүлж,

сэтгэлээ засахаас эхэлнэ” гэж сургасан байдаг. Үүнийг манай байгууллага дээр аваад үзвэл Мөргөлийн гурван эрдэнэд тулгуурлан энэрэн нигүүлсэх сэтгэл, хүний уг мөн чанар болох гэгээлэг, эелдэг, халуун дулаан сэтгэлийг эрхэмлэн бодисадвагийн үйлийг хэрэгжүүлэх нь гэр бүл, нийгэм, улс орон, дэлхийн энх тайванд шууд нөлөөлнө гэсэн үг болно.

Чухал зүйл бол хүн болгон үүнийг «зорилт»-оо болгож, улам бодитоор тодорхойлж, үргэлж санаж байхын тулд арга ухаанаа зарах хэрэгтэй.

Эцэст нь Их ариун ордон баригдсаны 51 жилийн ойг угтаж байгааг тохиолдуулан энэ жил алхам бүрээ нягталж, бодит байдалтай сэтгэл нэгдэн ургааш тэмүүлцгээе гэж хэлмээр байна.

Косей сонини хэсгээс, 2015 оны 1-р сарын 4 дугаар

Rissho Kosei-kai



RISSHO KOSEI-KAI INTERNATIONAL BRANCHES